



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 10 өдөр

Дугаар А/472

Ховд

Хамгаалалтын бүс тогтоох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а", 29.1.5-ын "в", Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5.1, 16 дугаар зүйлийн 16.1.3, 17 дугаар зүйлийн 17.2.2, аймгийн Онцгой комиссын 2021 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 78 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малын гоц халдварт шүлхий өвчин гарсантай холбогдуулан өвчний голомтыг хяналтад авах, тархалтыг зогсоох зорилгоор Дуут, Ховд, Буянт, Чандмань, Цэцэг, Зэрэг сумдын хилийн цэсийн дагуу хамгаалалтын бүс тогтоосугай.

2. Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Цагдаагийн газар /цагдаагийн хурандаа Э.Даваасүрэн/, Мал эмнэлгийн газар /Д.Батцэнгэл/, Мэргэжлийн хяналтын газар /П.Эрдэнэчулуун/, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Дэлгэрсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ